



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/22

Бор-Өндөр

Хагас жилийн эд хөрөнгийн тооллого
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 72 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 06 дугаар сарын 14-ний өдрийн хооронд тоолох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц. Жаргалсайхан

Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Э. Гуамарал

5 дугаар багийн Зохион байгуулагч

Гишүүд:

Д.Халиун

4 дүгээр багийн Зохион байгуулагч

Д. Мөнгөнтуяа

6 дугаар багийн Зохион байгуулагч

Ш.Цэрэндолгор

Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн

2. Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгийг тоолох тооллогын ажлыг зохион байгуулж, хяналт тавьж хууль, дүрэм журмын дагуу тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ц. Жаргалсайхан)-д даалгасугай.

ДАРГА

3. УУГАНЖАРГАЛ